

“БАНАНА” ОНЛАЙН ДЭЛГҮҮРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

УДИРТГАЛ

Энэхүү Үйлчилгээний нөхцөл (цаашид “Үйлчилгээний нөхцөл” гэх) нь нэг талаас онлайн худалдан авалт хийж буй хэрэглэгч (цаашид “Хэрэглэгч”, “Та” гэх) болон Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Нью Майнд Групп ХХК-ийн байр, 1 давхар хаягт байрлах **6381499** регистрийн дугаартай “Дижитал Молл” ХХК (цаашид “ДМ” эсхүл “Бид” гэх) нар /цаашид “Талууд” гэх/-ын хооронд үүсэх Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрт нэвтрэх, бүртгүүлэх, бүртгэл дээрээ үндэслэн бараа бүтээгдэхүүн худалдан авч, түүнийгээ хүргүүлэн авах (цаашид “Үйлчилгээ” гэх)-тэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Хэрэгжих журам

- 1.1. Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь Хэрэглэгч Үйлчилгээ авахынхаа өмнө уншиж танилцсаны үндсэн дээр хүлээн зөвшөөрч, “Зөвшөөрөв” товч дарснаар хэрэгжинэ.

2. Хэрэгжилтэд хяналт тавих

- 2.1. Энэхүү Үйлчилгээний нөхцөлийн хэрэгжилтэд Банана онлайн дэлгүүр болон Хэрэглэгч хамтран хяналт тавина.

3. Нэр томъёоны тайлбар

- 3.1. “**Банана онлайн дэлгүүр**” гэж ДМ-ийн хөгжүүлсэн, Мерчантын бараа бүтээгдэхүүний мэдээлэл байршиж, Хэрэглэгч өөрийн Хувийн бүртгэл үүсгэсний үндсэн дээр худалдан авалт хийх болон бусад үйлчилгээ авах боломжтой Banana аппликейшн, Аппликейшнд байрлах Banana цэс, эсхүл <https://bananamall.mn/> веб хуудас зэрэгт ажиллаж буй программ хангамжийг;
- 3.2. “**Сагс**” гэж Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүний мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр худалдан авахаар сонгох үед Хэрэглэгчийн худалдан авахаар сонгосон бараа бүтээгдэхүүнүүдийг нэгтгэн байршуулж буй хэрэгслийг;
- 3.3. “**Захиалга**” гэж Хэрэглэгч худалдан авахаар сонгож, сагсанд байршуулсан бараа бүтээгдэхүүний төлбөр төлснийг;
- 3.4. “**Захиалгын мэдээлэл**” гэж Хэрэглэгчийн захиалгатай холбоотой барааны нэр, төрөл, өнгө, хэмжээ, тоо ширхэг, үнэ, хүргэлтийн хаяг (үүгээр хязгаарлагдахгүй) зэрэг мэдээллийг;
- 3.5. “**Захиалга цуцлах**” гэж Захиалга баталгаажсанаас хойш бараа бүтээгдэхүүн Хүргэлтэд гарахаас өмнө Үйлчилгээний нөхцөлийн 10-д заасан үндэслэлээр Захиалга цуцалж буй үйлдлийг;
- 3.6. “**Бараа бүтээгдэхүүн буцаах, солиулах**” гэж Захиалга хүлээн авах болон хүлээн авсны дараах хугацаанд Үйлчилгээний нөхцөлийн 15-д заасан үндэслэлээр буцааж буй Хэрэглэгчийн үйлдлийг;
- 3.7. “**Хувийн бүртгэл**” гэж Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлийн 17.1-д заасан мэдээллийг Банана онлайн дэлгүүрт бүртгүүлсэн, эсхүл дамжуулах зөвшөөрөл өгснөөр Хэрэглэгчийн нэр дээр үүсэх худалдан авалт хийх эрх үүсгэж буй бүртгэлийг;
- 3.8. “**Хүргэлтийн ажилтан**” гэж Хэрэглэгчийн баталгаажуулсан Захиалгыг түүний өгсөн

- хаягийн дагуу хүргэж өгөх үүргийг хүлээж буй этгээдийг;
- 3.9. **“Бараа бүтээгдэхүүний үнэ”** гэж нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид “НӨАТ” гэх) нэмэгдсэн бараа бүтээгдэхүүний эцсийн жижиглэн худалдаалах үнийг;
- 3.10. **“Хүргэлтийн хөлс”** гэж Захиалгыг Хэрэглэгчийн өгсөн хаягт хүргэхтэй холбоотой Үйлчилгээний нөхцөлийн 13-р зүйлд заасан хөлсийг;
- 3.11. **“Захиалгын нийт үнийн дүн”** эсхүл **“Нийт төлбөр”** гэж Хэрэглэгчийн өгсөн Захиалгатай холбоотойгоор Банана онлайн дэлгүүрт төлбөл зохих үнийн дүн буюу Бараа бүтээгдэхүүний үнэ болон Үйлчилгээний нөхцөлийн 13-р зүйлд заасан Хүргэлтийн хөлсийн нийлбэрийг;
- 3.12. **“Хүргэлтэд гарахаас өмнө”** гэж Захиалгыг баталгаажуулснаас хойш Хүргэлтийн ажилтан Захиалгыг Хэрэглэгчид хүлээлгэн өгөхөөр, бараа бүтээгдэхүүнийг өөртөө хүлээн авах хүртэл үеийг ;
- 3.13. **“Доголдол”** гэж бараа бүтээгдэхүүний биет байдлын болон эрхийн доголдлыг;
- 3.14. **“Аппликейшн”** гэж ДМ-ийн хөгжүүлж, “LendMN” эсхүл “SuperUp” нэртэй программ хангамжид тусгай цэс болгон байршуулсан Банана онлайн дэлгүүрийг;
- 3.15. **“Banana аппликейшн”** гэж Хэрэглэгч ухаалаг гар утас, бусад төхөөрөмжид татан авч ашиглах боломжтой, ДМ-с хөгжүүлж, Банана онлайн дэлгүүрийг байршуулсан өөрийн программ хангамжийг;
- 3.16. **“Зөвшөөрөх үйлдэл”** гэж Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрт хандан Захиалга баталгаажуулах, өөрийн мэдээллийг үнэн зөв гэдгийг батлах, холбогдох бусад үйлдлийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлэхийн тулд Банана онлайн дэлгүүрт хийж буй Хэрэглэгчийн үйлдлийг;
- 3.17. **“Мерчант”** гэж өөрийн бараа бүтээгдэхүүний мэдээллийг Банана онлайн дэлгүүрт байршуулж, Хэрэглэгчид санал болгон борлуулахаар ДМ-тай хамтран ажиллаж буй хуулийн этгээд, эсхүл хувь хүнийг;
- 3.18. **“Санхүүгийн үйлчилгээ”** гэж Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрээс худалдан авалт хийхэд зориулан ДМ-тэй хамтран ажиллагч байгууллагаас санал болгож буй, бараа бүтээгдэхүүний Нийт төлбөрийг Банана онлайн дэлгүүрт зээлээр болон хувааж төлөх төлбөрт нөхцөлөөр хялбараар төлөх боломж олгож буй үйлчилгээнүүдийг.

БҮРТГЭЛ

4. Үйлчилгээ авах үндэслэл

- 4.1. Хэрэглэгчийн Хувийн бүртгэл хийгдсэнээр Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрийг ашиглах бүрэн эрх үүснэ.

5. Насны хязгаар

- 5.1. Хэрэглэгч нь 18 насанд хүрсэн байх ёстой бөгөөд 18 насанд хүрээгүй этгээд Хэрэглэгч болохыг хориглоно.
- 5.2. ДМ нь бүртгэгдэж буй Хэрэглэгчийг 18 нас хүрсэн эсэхийг биечлэн шалгах боломжгүй тул Хэрэглэгч Зөвшөөрөх үйлдлээр баталгаажуулснаар түүнийг 18 нас хүрсэн этгээд гэж ДМ үзнэ.
- 5.3. 18-аас доош насны этгээдийг Хувийн бүртгэл үүсгэж буй тохиолдолд өөрийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах аливаа хохирол, гэм хорыг ДМ хариуцахгүй.
- 5.4. Банана онлайн дэлгүүрт мэдээлэл нь байршсан зарим бараа бүтээгдэхүүнийг захиалан авах насны доод хязгаар нь холбогдох хууль тогтоомжийн дагуу 21 нас байна. Хэрэглэгч 21 нас хүрсэн гэдгээ Зөвшөөрөх үйлдлээр баталгаажуулсны үндсэн дээр тухайн бараа бүтээгдэхүүнийг захиалан авах үүрэгтэй.
- 5.5. ДМ нь Хэрэглэгчийг 21 нас хүрсэн эсэхийг биечлэн шалгах боломжгүй тул Хэрэглэгчийн хийсэн Зөвшөөрөх үйлдлийг үндэслэн түүнийг 21 нас хүрсэн этгээд гэж үзнэ. 21 нас хүрээгүй хэрэглэгч Зөвшөөрөх үйлдлээр дамжуулан Захиалга хийснээс үүдэн гарах аливаа хохирол, гэм хорыг ДМ хариуцахгүй.

6. Бүртгэл хувийн байх

- 6.1. Хэрэглэгч нь зөвхөн өөрийн бүртгүүлсэн Хувийн бүртгэлээрээ дамжуулан Банана онлайн дэлгүүрийг ашиглана.
- 6.2. Хэрэглэгч нь өөрийн Хувийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн нууцаа чандлан хамгаалах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.
- 6.3. Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлийн 6.2-т заасан үүргээ зөрчсөнөөс өөрт нь болон гуравдагч этгээдэд учирсан хохирол, гэм хорыг ДМ хариуцахгүй бөгөөд ДМ-д учирсан хохирол, гэм хорыг Хэрэглэгч хариуцан арилгах үүрэгтэй.

7. Хувийн бүртгэл үүсгэх

- 7.1. Хэрэглэгч энэхүү дор дурдсан мэдээллийг Банана онлайн дэлгүүрт бүрэн оруулах буюу өөрөө үүсгэснээр, эсхүл Аппликейшнд холбогдох үйлдлийг хийж, ДМ-д дамжуулахыг зөвшөөрснөөр Хувийн бүртгэл үүсэх ба Банана онлайн дэлгүүрийг ашиглах эрх нээгдэнэ.
 - 7.1.1.Хэрэглэгчийн утас эсвэл и-мэйл хаяг;
 - 7.1.2.Хэрэглэгч өөрөө нууц үгээ үүсгэж, оруулах.

- 7.2. Хэрэглэгч өөрийн мэдээллийн үнэн зөвийг бие даан хариуцна.
- 7.3. Хэрэглэгчийн Хувийн бүртгэлийн мэдээлэл бүрэн бус, алдаатай, буруу байсны улмаас ДМ болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирол, гэм хорыг Хэрэглэгч бие даан хариуцан арилгах үүрэгтэй.

ЗАХИАЛГА

8. Захиалга өгөх

- 8.1. Хэрэглэгч нь Захиалгаа хоногийн 24 цагийн хугацаанд хэдийд ч хийх боломжтой байна.
- 8.2. Хэрэглэгч нь Захиалга хийхдээ Банана онлайн дэлгүүрийн санал болгож буй бараа бүтээгдэхүүний мэдээлэлтэй сайтар танилцаж, тэдгээрээс сонголт хийж, тус сонгосон бараа бүтээгдэхүүнээ Сагсанд хийж, төлбөр төлөх арга хэрэгслээ сонгосноор Захиалга үүснэ.
- 8.3. Хэрэглэгч нь нэг Захиалгаар хэд хэдэн бараа бүтээгдэхүүн захиалж болно.
- 8.4. Хэрэглэгч нь Санхүүгийн үйлчилгээ ашиглах бол тухайн Санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагын үйлчилгээний мэдээлэл, нөхцөлтэй сайтар танилцаж, шаардлагатай тохиолдолд Банана онлайн дэлгүүр, эсхүл Санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагаас тодруулсаны үндсэн дээр Захиалга хийх үүрэгтэй.

9. Захиалга баталгаажих

- 9.1. Хэрэглэгч Banana аппликейшн, Аппликейшн, эсхүл <https://bananamall.mn/> веб хуудсаар дамжуулан Банана онлайн дэлгүүрээс Захиалга хийх бөгөөд тухайн захиалсан бараа бүтээгдэхүүний Нийт төлбөрийг өөрөө төлсөн, эсхүл Санхүүгийн үйлчилгээг ашиглан төлсөн тохиолдолд Захиалга баталгаажна.
- 9.2. Хэрэглэгч нь Захиалгаа баталгаажуулахын өмнө Захиалгын мэдээлэл, хэрэв Санхүүгийн үйлчилгээг ашиглаж буй бол тухайн Санхүүгийн үйлчилгээний нөхцөл, мэдээллийг тус тус үнэн зөв байгаа эсэхийг нягталж шалгах үүрэгтэй.
- 9.3. Хэрэглэгч нь Үйлчилгээний нөхцөлийн 9.2-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас Захиалгаа буруу хийж, баталгаажуулсан бол бараа бүтээгдэхүүн буцаах (Хэрэглэгчийн өгсөн хаягт хүргэх болон буцааж Банана онлайн дэлгүүрт хүргэх)-тай холбоотой Хүргэлтийн хөлсийг бүрэн хариуцна.
- 9.4. Барааны төрөл, хэлбэр, жин, овор хэмжээнээс хамааран захиалга болон хүргэлт хийх хугацаа харилцан адилгүй байх боломжтой. Хэрэв Хэрэглэгчийн захиалсан бараа бүтээгдэхүүн онцгой шинж чанартай байх тохиолдолд тухайн үед нь Хэрэглэгчид мэдэгдэх, тодруулах, Захиалгыг дахин баталгаажуулж хүргэлтийн нөхцөлийг тодорхойлно.

10. Захиалга цуцлах

- 10.1. Банана онлайн дэлгүүрийн зүгээс дараах тохиолдолд Захиалгыг цуцлах эрхтэй:
 - 10.1.1. Хэрэглэгч Нийт төлбөрөө төлж Захиалгаа баталгаажуулаагүй;
 - 10.1.2. Банана онлайн дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүний үнэ буруу тавигдсан;
 - 10.1.3. Хэрэглэгч Нийт төлбөрийг дутуу, эсхүл буруу шилжүүлсэн;
 - 10.1.4. Хэрэглэгчийн захиалсан бараа бүтээгдэхүүнийг худалдах боломжгүй болсон (дууссан, гэмтэлтэй бараа үлдсэн гэх мэт);
 - 10.1.5. Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг цааш нь дамжуулан зардаг байж болзошгүй гэх эргэлзээ төрсөн;
 - 10.1.6. Үйлчилгээний нөхцөлийн 25.1-д заасан давагдашгүй хүчин зүйл үүссэн үед Бидний зүгээс Захиалгыг хүргэх боломжгүй болсон;

- 10.1.7. Хувийн бүртгэл, Захиалга өгөх мэдээллийг буруу, дутуу, худлаа бөглөсөн;
- 10.1.8. Хэрэглэгч Санхүүгийн үйлчилгээнээс татгалзсан буюу цуцлах хүсэлтийг Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад гаргасан.
- 10.2. Хэрэглэгчийн зүгээс дараах тохиолдолд Захиалгыг цуцлах эрхтэй:
- 10.2.1. Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлийн 9.1-д заасны дагуу Нийт төлбөрөө төлж Захиалгаа баталгаажуулаагүй үед;
- 10.2.2. Хэрэглэгч Нийт төлбөр төлж Захиалгаа баталгаажуулсны дараа, бараа бүтээгдэхүүн Хүргэлтэд гарахаас өмнө Банана онлайн дэлгүүрт мэдэгдсэн.
- 10.2.3. Хэрэв Хэрэглэгч Нийт төлбөрөө Санхүүгийн үйлчилгээ ашиглан төлсөн бол тухайн Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага зөвшөөрсөн тохиолдолд Захиалгаа цуцалж болно.
- 10.3. Хэрэглэгчийн Захиалга баталгаажсаны дараа Үйлчилгээний нөхцөлийн 10.1.2-10.1.8 болон 10.2.2-т заасны дагуу цуцлагдсан бол төлбөрийг Хэрэглэгчийн нэр дээрх банкин дахь дансанд 100 хувь буцаан шилжүүлнэ. Хэрэв 10.2.3-т заасны дагуу цуцлагдсан бол Хэрэглэгчийн авсан Санхүүгийн үйлчилгээг цуцлах, тухайн үйлчилгээг ашиглах үед Хэрэглэгчээс төлсөн төлбөрийг түүнд буцаах асуудлыг Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 10.4. Банана онлайн дэлгүүр нь Үйлчилгээний нөхцөлийн 10.1, 10.2.1-д заасан үндэслэлээр Захиалгыг хэдийд ч цуцлах эрхтэй.
- 10.5. Хэрэглэгч нь 10.2.2-д заасан үндэслэлээр Захиалгаа цуцлах бол Захиалга цуцлах тухай хүсэлтийг зөвхөн Захиалга Хүргэлтэд гарахаас өмнө гаргах эрхтэй ба Захиалга цуцлах тухай хүсэлтээ Банана онлайн дэлгүүрийн **77774080 дугаарын** утсаар мэдэгдэх үүрэгтэй.

ХҮРГЭЛТ

11. Хүргэлтийн хуваарь

- 11.1. Хэрэглэгч Захиалгыг баталгаажуулснаас хойш Банана онлайн дэлгүүр нь Захиалгыг Хүргэлтэд гаргах ажиллагааг эхлүүлнэ.
- 11.2. Хэрэглэгч хүсвэл Хүргэлтэд гарахад бэлэн болсон Захиалгыг Банана онлайн дэлгүүр, эсхүл Мерчантаас өөрийн биеэр ирж авч болно. Энэ тохиолдолд Хэрэглэгч Хүргэлтийн хөлс (хэрэв бий бол) төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.
- 11.3. Хэрэглэгчийн Захиалсан бараа бүтээгдэхүүний овор хэмжээ, онцлогоос шалтгаалж Захиалгыг Мерчант өөрөө Хэрэглэгчид хүргэж болно. Энэ тохиолдолд хүргэлтийн хугацаа Үйлчилгээний нөхцөлийн 11.4.1-т зааснаас өөр байж болно.
- 11.4. Хэрэглэгчийн Захиалга хүргүүлэх хаяг нь Үйлчилгээний нөхцөлийн 12.1-д заасан хүргэлтийн хязгаар дотор бол:
- 11.4.1. Захиалга баталгаажсанаас хойш 24-72 цагийн дотор хүргэлт хийнэ.
- 11.4.2. Бүх нийтийн амралтын өдөр Захиалгаа баталгаажуулсан бол уг Захиалгын баталгаажуулалтыг дараагийн ажлын өдрийн Захиалга руу шилжүүлж тооцно.
- 11.4.3. Зарим бараа бүтээгдэхүүнийг холбогдох хууль, тогтоомжид заасан өдөр болон цагийн хязгаарлалтын хүрээнд багтаан хүргэнэ.
- 11.5. Банана онлайн дэлгүүр нь бараа бүтээгдэхүүний жин, овор хэмжээ болон Захиалга хүргэх байршлын хол зэрэг нөхцөлөөс шалтгаалан Үйлчилгээний нөхцөлийн 11.4-т заасан хүргэлтийн хугацааг хойшлуулж болно.

12. Хүргэлтийн хязгаар

- 12.1. А бүс буюу дараах цэгүүдээр хязгаарлан хот доторх хүргэлт хийгдэнэ. Үүнд:

- 12.1.1. 32-ийн тойрог;
- 12.1.2. Оффицер;
- 12.1.3. Зайсан;
- 12.1.4. Таван шар
- 12.1.5. Нүхт.

13. Хүргэлтийн хөлс

- 13.1. Хэрэглэгчийн Захиалга 100,000 (нэг зуун мянга) төгрөгтэй тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд хүргүүлэх хаяг нь Үйлчилгээний нөхцөлийн 12.1-т заасан хүргэлийн хязгаар буюу А бүс дотор бол үнэ төлбөргүй хүргэнэ.
- 13.2. Хэрэглэгчийн Захиалга 99,999 (ерөн есөн мянга есөн зуун ерэн ес) төгрөгтэй тэнцүү буюу түүнээс доош үнийн дүнтэй, хүргэлийн хязгаар буюу А бүс дотор хүргүүлэн авах бол Хүргэлтийн хөлс нь 4000 (дөрвөн мянга) төгрөг байна.
- 13.3. Хэрэв Хэрэглэгчийн захиалсан бараа бүтээгдэхүүний овор хэмжээ нь 30 кг-аас дээш, эсхүл тухайн Мерчант зөвхөн хүргэдэг бол Хүргэлтийн хөлс Мерчантын хүргэлтийн тарифаар тооцогдоно.
- 13.4. Хэрэглэгчээс шалтгаалан түүний Захиалгыг 2 болон түүнээс дээш удаа хүргэх болон Хэрэглэгчийн анх зааснаас өөр хаяг, газарт Захиалгыг хүргэсэн тохиолдолд шинэ хүргэлт эхэлсэн гэж үзэн Хүргэлтийн хөлсийг тухай бүр нэмж тооцно. Энэ тохиолдолд тухай бүр нэмж тооцох Хүргэлтийн хөлс нь 4000 (дөрвөн мянга) төгрөг байна.

14. Хүлээж авах

- 14.1. Хэрэглэгч хүргүүлэх хаяг, холбоо барих утасны дугаараа (маш тодорхой) үнэн зөв бөглөх үүрэгтэй ба буруу мэдээллээс болж үүдэн гарах аливаа гэм хор, хохирлыг Хэрэглэгч хариуцна.
- 14.2. Хэрэглэгч хүргэлт хийгдэх цагаар утсаа нээлттэй байлгах, өөрийн Хувийн мэдээлэлд заасан, эсхүл Захиалга хийх үед Банана онлайн дэлгүүрт өөрөө оруулсан хаяг дээрээ байх үүрэгтэй.
- 14.3. Хэрэв Хэрэглэгч өөрөө Захиалгаа хүлээн авах боломжгүй бол Хэрэглэгчийг төлөөлөн Захиалга хүлээн авах этгээдийн мэдээллийг Банана онлайн дэлгүүрийн **77774080** дугаарын утсанд мэдэгдэнэ.
- 14.4. Үйлчилгээний нөхцөлийн 14.3-д заасан этгээдэд Захиалгыг хүлээлгэн өгснийг Захиалга хүргэсэнд тооцно.
- 14.5. Хэрэглэгч болон түүний оронд Захиалга хүлээн авах этгээд нь Захиалга хүлээн авахдаа бичиг баримтаа Хүргэлтийн ажилтанд шалгуулсны үндсэн дээр Захиалгаа хүлээн авах үүрэгтэй. Хэрэв Үйлчилгээний нөхцөлийн 5.4-т заасны дагуу, эсхүл Санхүүгийн үйлчилгээг анх удаа ашиглан Захиалга хийсэн бөгөөд тухайн Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан бол Хэрэглэгч зөвхөн өөрөө Захиалгыг хүлээн авах ба өөрийн бичиг баримтаа Хүргэлтийн ажилтанд шалгуулах, Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас илгээсэн баримт бичгийг зохих ёсоор баталгаажуулах үүрэгтэй. Хэрэглэгч энэ үүргээ биелүүлээгүй бол Банана онлайн дэлгүүр Захиалгыг буцаах эрхтэй.
- 14.6. Хэрэглэгч Захиалгыг Хүргэлтийн ажилтны дэргэд бүрэн бүтэн байдал, тоо ширхэг, Захиалгын мэдээллийн дагуу байгаа эсэхийг шалган хүлээж авах үүрэгтэй ба бараа бүтээгдэхүүн гэмтсэн (сав баглаа боодол урагдсан, зурагдсан, халтарсан зэрэг бараа бүтээгдэхүүнд чанарт нөлөөлөхгүй өнгөц гэмтлийг тооцохгүй), эвдэрсэн байсан тохиолдолд Хэрэглэгч Захиалсан бараа бүтээгдэхүүнийг солиулах, эсхүл буцааж болно.

- 14.7. Үйлчилгээний нөхцөлийн 14.6-д заасан үндэслэлээр Захиалгыг буцааж байгаатай болон хүргэлттэй холбоотой бусад асуудалд ДМ хариуцлага хүлээнэ.
- 14.8. Хэрэглэгч Захиалгыг шалгаж Захиалгын дагуу, бүрэн бүтэн байна гэж үзвэл хүлээн авахдаа хүргэлтийн маягт дээр гарын үсэг зуран баталгаажуулж болно.
- 14.9. Бараа бүтээгдэхүүн гэмтэлтэй тохиолдолд Хэрэглэгч хүргэлтийн бараа бүтээгдэхүүнийг буцаах эрхтэй бөгөөд Банана онлайн дэлгүүрийн **77774080 дугаарын** утсаар холбогдон бараа бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй шалтгааныг тодорхой хэлж мэдэгдэнэ.
- 14.10. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах баримтад Хэрэглэгч гарын үсгээ зурсан, эсхүл бараа бүтээгдэхүүнийг хүлээж авсан тохиолдолд Хэрэглэгчид бараа бүтээгдэхүүн бүрэн бүтнээрээ очсон гэж үзнэ.
- 14.11. Хэрэглэгчийн худалдан авсан бараа бүтээгдэхүүний хүргэлтэд бараа бүтээгдэхүүнийг угсрах болон суурилуулах ажил орохгүй.

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН БУЦААХ, СОЛИУЛАХ

15. Бараа бүтээгдэхүүн буцаах, солих нөхцөл

- 15.1. Үйлчилгээний нөхцөлийн 14.6-д зааснаас гадна дараах үндэслэлээр Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнээ буцаах, эсхүл солиулах хүсэлтээ Банана онлайн дэлгүүрийн **77774080** дугаарын утсанд холбогдож мэдэгдэх, эсхүл захиалгын дугаар болон өөрт тулгарсан нөхцөл байдал бүхий мэдээллийг тусгасан хүсэлтийг contact@bananamall.mn и-мэйл хаягт бичиж илгээн буцаах, эсхүл солиулах боломжтой:
 - 15.1.1. Захиалгын бүрэн бүтэн байдал алдагдсан, хайрцаг баглаа, баримт бичиг (баталгааны хуудас, ибаримтын хуудас зэрэг) бүрэн бус үед Захиалга хүлээн авснаас хойш 24 цагийн дотор буцаах, эсхүл солиулах тухай мэдэгдсэн бол;
 - 15.1.2. Бараа бүтээгдэхүүн мэдэгдэхүйц гэмтэлтэй тохиолдолд Захиалга хүлээн авснаас хойш 24 цагийн дотор холбогдон буцаах, эсхүл солиулах тухай мэдэгдсэн бол;
 - 15.1.3. Захиалсан бараа бүтээгдэхүүнээс өөр төрлийн бараа бүтээгдэхүүн очсон /загвар, хэлбэр хэмжээ, марк зөрсөн/ тохиолдолд Захиалга хүлээн авснаас хойш 24 цагийн дотор холбогдон буцаах, эсхүл солиулах тухай мэдэгдсэн бол;
 - 15.1.4. Бараа бүтээгдэхүүнд Доголдол, гэмтэл илэрсэн бол баталгаат хугацаа (хэрэв бий бол)-ны дотор буцаах, эсхүл солиулах тухай мэдэгдсэн бол.
- 15.2. Хэрэглэгч нь Үйлчилгээний нөхцөлийн 15.1-д заасан үндэслэлээс бусад үндэслэлээр Захиалга буцаах хүсэлт гаргавал Банана онлайн дэлгүүр бараа бүтээгдэхүүнийг буцаах, эсхүл солих үүрэг хүлээхгүй.
- 15.3. Хэрэглэгчийн буцаах, эсхүл солиулах бараа бүтээгдэхүүн нь бүрэн бус, гэмтэлтэй, ашиглагдсан бол бараа бүтээгдэхүүнийг Банана онлайн дэлгүүр буцаан авах үүрэг хүлээхгүй.
- 15.4. Банана онлайн дэлгүүрийн бодлого, Мерчанттай харилцан тохиролцсоны дагуу зарим брэндийн бараа бүтээгдэхүүнд ямар ч тохиолдолд буцаалт хийхгүй бөгөөд тухайн барааг зөвхөн солиулах боломжтой. Банана онлайн дэлгүүр нь энэ талаар холбогдох тайлбарыг оруулах бөгөөд Хэрэглэгч түүнтэй сайтар танилцсаны үндсэн дээр худалдан авалт хийх үүрэгтэй.

16. Бараа бүтээгдэхүүн буцаасан, солиулсны үр дагавар

- 16.1. Хэрэв Хэрэглэгч Нийт төлбөрөө өөрөө төлсөн бөгөөд бараа бүтээгдэхүүнийг Үйлчилгээний нөхцөлийн 15.1-д заасан үндэслэлээр буцаах хүсэлт гаргасан бол Банана

онлайн дэлгүүр нь хүсэлтийг шийдвэрлэж, бараа бүтээгдэхүүний төлбөрийг ажлын 2 хоногийн дотор Хэрэглэгчийн нэр дээрх банкин дахь дансанд 100 хувь буцаан шилжүүлнэ.

- 16.2. Хэрэв хэрэглэгч Нийт төлбөрөө Санхүүгийн үйлчилгээ ашиглан төлсөн бөгөөд бараа бүтээгдэхүүнийг Үйлчилгээний нөхцөлийн 15.1-д заасан үндэслэлээр буцаах хүсэлт гаргасан бол Банана онлайн дэлгүүр нь тухайн Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад нэн даруй мэдэгдэх ба Хэрэглэгчийн авсан Санхүүгийн үйлчилгээг цуцлах, тухайн үйлчилгээг ашиглах үед Хэрэглэгчээс төлсөн төлбөрийг түүнд буцаах асуудлыг Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 16.3. Хэрэв хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг Үйлчилгээний нөхцөлийн 15.1-д заасан үндэслэлээр солиулах хүсэлт гаргасан бол Банана онлайн дэлгүүр нь хүсэлтийг шийдвэрлэж, ажлын 2 хоногийн дотор сольж, Хэрэглэгчид хүргүүлнэ. Бараа бүтээгдэхүүн буцаах, эсхүл солиулахтай холбогдон гарсан зардал, Санхүүгийн үйлчилгээнээс үүдэн Хэрэглэгчид учирсан зардлыг ДМ хариуцана.
- 16.4. Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг буцаах, эсхүл солиулахдаа Хүргэлтийн ажилтнаар дамжуулан, эсхүл Банана онлайн дэлгүүрээс зөвшөөрсөн бусад арга хэлбэрээр бараа бүтээгдэхүүнийг буцаах, эсхүл солиулна.

МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, БОДЛОГО

17. Хэрэглэгчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго

- 17.1. Бид Хэрэглэгчийн мэдээллийг зөвхөн дор дурдсан зорилгоор цуглуулж, боловсруулж, ашиглана:
- 17.1.1. Хэрэглэгчид Банана онлайн дэлгүүрийг ашиглах эрх үүсгэх, олгох;
 - 17.1.2. Хэрэглэгчийн Банана онлайн дэлгүүрт нэвтрэх, Банана онлайн дэлгүүрт хийсэн аливаа Зөвшөөрөх үйлдлийг баталгаажуулах;
 - 17.1.3. Хэрэглэгчийн утас болон и-мэйл хаяг руу шаардлагатай захиалгын мэдээлэл илгээх;
 - 17.1.4. Захиалга хүргэх;
 - 17.1.5. Хямдрал, урамшуулалтай холбоотой мэдээллийг хүргэх;
 - 17.1.6. Шинэ бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох;
 - 17.1.7. Банана онлайн дэлгүүрийн систем, модулийн судалгаа, сайжруулалт, хөгжүүлэлт, хяналт, туршилт, засварт холбогдуулан ашиглах;
 - 17.1.8. Хэрэглэгчид Санхүүгийн үйлчилгээ ашиглахад шаардлагатай мэдээллийг тухайн Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дамжуулах;
 - 17.1.9. Сурталчилгаа харуулах.
- 17.2. Бид Хэрэглэгч зөвшөөрч өөрөө оруулсан, Зөвшөөрөх үйлдэл хийсэн, эсхүл Аппликейшнд холбогдох үйлдлийг хийсний үндсэн дээр Аппликейшнаас Банана онлайн дэлгүүрт дамжуулахыг зөвшөөрсөн дараах мэдээллийг цуглуулан авч, боловсруулж, ашиглана. Үүнд:
- 17.2.1. Хэрэглэгчийн овог нэр;
 - 17.2.2. Хэрэглэгчийн төрсөн огноо;
 - 17.2.3. Хэрэглэгчийн утасны дугаар;
 - 17.2.4. Хэрэглэгчийн и-мэйл хаяг;
 - 17.2.5. Хэрэглэгчийн хүйс;
 - 17.2.6. Хэрэглэгчийн хүргэлтийн хаяг;
 - 17.2.7. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас шаардсан бусад мэдээлэл.

- 17.3. Бид Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрийг ашиглах явцад Хэрэглэгчийн захиалгын түүх, хадгалсан буюу хүслийн жагсаалтад нэмсэн бараа бүтээгдэхүүний түүх, хүргэлтийн хаяг зэрэг мэдээллийг хүний оролцоогүй, цахим хэлбэрээ боловсруулж, ашиглах ба ингэснээр Хэрэглэгчид Банана онлайн дэлгүүрийг цаашид хялбараар ашиглах, өөрийн захиалгыг хянах боломжийг олгоно.
- 17.4. Бид Хэрэглэгчийн хандалтын талаар хадгалсан браузерийн зарим мэдээллүүд (цаашид “Cookies” гэх)-ийг цуглуулна. Хэрэглэгч Cookies авахгүйгээр манай үйлчилгээг ашиглах боломжтой бөгөөд ийнхүү ашиглах тохиолдолд браузерт шаардлагатай тохиргоог хийж болно.
- 17.5. Хэрэглэгч нь өөрийн бүртгүүлсэн мэдээлэл (өөрийн утасны дугаар, цахим шуудан, хүргэлтийн хаяг гэх мэт) Банана онлайн дэлгүүрт нэвтрэн өөрчлөх, шинэчлэх боломжтой.

18. Мэдээлэл өгөхөөс татгалзах, түүний үр дагавар

- 18.1. Хэрэглэгч мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрөл олгохоос тухай бүр татгалзах буюу Банана онлайн дэлгүүрт мэдээллээ өгөхгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд Банана онлайн дэлгүүрээс тухайн мэдээллийг ашигласны үндсэн дээр үзүүлдэг зарим үйлчилгээг ашиглах боломжгүй болно.
- 18.2. Хэрэглэгч үүссэн нөхцөл байдлын тухай гомдлоо Банана онлайн дэлгүүрийн 77774080 дугаарт, эсхүл contact@bananamall.mn и-мэйл хаягаар холбогдон гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй байна.

19. Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах, ашиглах

- 19.1. Бид Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангах боломжит бүхий л арга хэмжээг авч, хамгаалж ажиллана.
- 19.2. ДМ нь Хэрэглэгчийн ДМ-д өгсөн өөрийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах тухай зөвшөөрөл цуцлагдах хүртэл, эсхүл Хэрэглэгчийн мэдээллийг устгах хүртэл хугацаанд ашиглана.
- 19.3. Бид Хэрэглэгчийн мэдээллийг ашиглан түүний Хувийн бүртгэлд нэвтрэх боломжгүй бөгөөд зөвхөн тухайн Хэрэглэгч л өөрийн нэвтрэх эрхийг ашиглан Хувийн бүртгэлдээ хандах, Банана онлайн дэлгүүрийг ашиглах эрхтэй.
- 19.4. Хэрэглэгч өөрийн мэдээллийн нууцлал, нэвтрэх нэр, нууц үгээ аливаа Гуравдагч этгээдэд задруулалгүй өөрийн Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

20. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг зогсоох, мэдээлэл устгах, сэргээх нөхцөл

- 20.1. Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрт байрлах “Зөвшөөрлөө цуцлах” сонголтыг сонгож, өөрийн нууц үгээр баталгаажуулан хүсэлтээ илгээнэ.
- 20.2. ДМ хүсэлтийг хүлээн авч, Хэрэглэгчийн хүсэлт ДМ-ийн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй гэж үзвэл мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг зогсоож, Хувийн бүртгэлийг хүчингүй болгох ба Хэрэглэгчид энэ тухай мэдэгдэнэ. Дараах нөхцөлд Хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авахгүй:
 - 20.2.1. Хэрэглэгчийн Захиалга хийсэн бөгөөд Захиалгыг түүнд хүлээлгэн өгөөгүй байгаа;
 - 20.2.2. Хэрэглэгч бараа бүтээгдэхүүн буцаах, солиулах хүсэлт гаргасан, эсхүл түүнийг шийдвэрлэх үйл ажиллагаа явагдаж байгаа;
 - 20.2.3. Хэрэглэгч Санхүүгийн үйлчилгээ ашигласан бөгөөд тухайн Санхүүгийн үйлчилгээг ашиглагч байгууллагатай төлбөр тооцоотой бол.

- 20.3. Хэрэглэгчийн зөвшөөрөл цуцлагдсан тохиолдолд Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрийг үргэлжлүүлэн ашиглах боломжгүй болох бөгөөд зөвшөөрөл цуцлагдахаас өмнө цуглуулсан, боловсруулсан мэдээлэл нь Банана онлайн дэлгүүрт хэвээр үлдэнэ.
- 20.4. Хэрэглэгч Банана онлайн дэлгүүрийг үргэлжлүүлэн ашиглах хүсэлтэй бол Хувийн бүртгэлээ шинээр үүсгэж, Хэрэглэгч өөрөө зөвшөөрсөн бол өмнөх мэдээллээ үргэлжлүүлэн ашиглаж болно.
- 20.5. Хэрэглэгчийн мэдээллийг зөвхөн хуульд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд устгана. Устгасан мэдээллийг дахин сэргээх боломжгүй байна.

21. Хувийн мэдээлэл гуравдагч этгээдэд ашиглуулах

- 21.1. Банана онлайн дэлгүүр нь Хэрэглэгчийн мэдээллийг олон нийтэд задруулахгүй бөгөөд зөвхөн дараах тохиолдолд Хэрэглэгчийн мэдээллийг дор дурдсан гуравдагч этгээдэд дамжуулна. Үүнд:
 - 21.1.1. Эрх бүхий байгууллагын албан ёсны шийдвэр, шаардлагын дагуу тус байгууллагад хуульд заасан хэлбэр, хэмжээний хүрээнд;
 - 21.1.2. Банана онлайн дэлгүүр цугларсан мэдээллийг Хэрэглэгчийг хувь хүний хувьд оноон таньж мэдэх боломжгүй болгон, судалгаа, шинжилгээний зорилгоор гуравдагч этгээдэд;
 - 21.1.3. Хэрэглэгчийн мэдээллийн нууцын аюулгүй байдлыг хангах хэлцэл хийсний үндсэн дээр Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дамжуулах;
 - 21.1.4. Хуулиар хориглоогүй бусад тохиолдол.
- 21.2. Банана онлайн дэлгүүр нь Хувийн мэдээллийг Үйлчилгээний нөхцөлийн 21.1-д зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд дамжуулахгүй.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА

22. Банана онлайн дэлгүүрийг ашиглахтай холбоотой зөвшөөрөл

- 22.1. Хэрэглэгч нь Банана онлайн дэлгүүрт оруулсан мэдээлэл, тэдгээрийн утга, нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, ПИН код, нэг удаагийн нууц үг зэргийг ашигласан, аливаа сонголт хийсэн, Зөвшөөрөх болон эдгээртэй ижил бусад үйлдлийг хийсэн нь хүчин төгөлдөр үйлдэл буюу хэлцэл гэж тооцогдоно.
- 22.2. Хэрэглэгч нь энэхүү Үйлчилгээний нөхцөлийг сайтар уншиж танилцсан байх үүрэгтэй бөгөөд танилцаагүйгээс үүдэн гарах аливаа хариуцлагыг ДМ хүлээхгүй.

23. Мэдээллийн нууцлал, бодлоготой холбоотой мэдэгдэл, баталгаа

- 23.1. Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлтэй танилцаж, хүлээн зөвшөөрснөөр ДМ-д өөрийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрхийг олгосонд тооцно.
- 23.2. Хэрэглэгч мэдээллийн нууцлал, бодлоготой бүрэн танилцсан бөгөөд тийнхүү танилцсан ч ойлгохгүй, эсхүл нэмж тодруулах зүйл байвал Банана онлайн дэлгүүрийн **77774080 дугаарт, эсхүл contact@bananamall.mn** и-мэйл хаягаар холбогдож тодруулах замаар мэдээлэл авна. Энэхүү Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр Хэрэглэгч мэдээллийн нууцлал, бодлогыг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

24. Хариуцлагаас чөлөөлөгдөх

24.1. ДМ нь дараах тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүнд:

- 24.1.1. Хэрэглэгч өөрийн сонгосон бараа бүтээгдэхүүний өнгө, хэмжээ хэлбэр зэргийг тодорхой мэдэж, сайтар шалган Зөвшөөрөх үйлдэл хийж захиалах үүрэгтэй бөгөөд Хэрэглэгчийн хүлээлтээс зөрсөн тохиолдолд;
- 24.1.2. Хэрэглэгч Захиалгыг худал, буруу хийсний үр дүнд Хэрэглэгчид хохирол учирсан тохиолдолд;
- 24.1.3. Хэрэглэгч өөрийн мэдээллийг бүрэн бус, алдаатай, буруу өгсөн тохиолдолд;
- 24.1.4. Хэрэглэгч Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тавигдсан шаардлагыг хангаагүйн улмаас Санхүүгийн үйлчилгээ авч чадаагүй тохиолдолд;
- 24.1.5. Давагдашгүй хүчин зүйлийн үед Хэрэглэгчид хохирол учирсан тохиолдолд.

ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

25. Давагдашгүй хүчин зүйлийн тодорхойлолт

25.1. Давагдашгүй хүчин зүйл гэж дайн (зарласан болон зарлаагүй), хорлон сүйтгэх ажиллагаа, бослого, үймээн, эмх замбараагүй байдал, олон нийтийг хамарсан Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, шүүхийн шийдвэр, гал түймэр, осол, дэлбэрэлт, хорио цээр, аадар бороо, цасан шуурга, газар хөдлөлт, гал ус зэрэг байгалийн ноцтой үзэгдэл, компьютерийн хакер, зөөврийн болон хадгалалтын төхөөрөмжид зөвшөөрөлгүй хандах, сүлжээ унагах, аюулгүй байдалд халдах, зам засвар, замын хөдөлгөөний хориг зэрэг зохих хяналтаас давсан үйл явдлыг хэлнэ.

26. Давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээ

- 26.1. Үйлчилгээний нөхцөлийн 25.1-д заасан нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас Банана онлайн дэлгүүр нь үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл Үйлчилгээ үзүүлэх хугацааг хойшлуулах болно.
- 26.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ утсаар эсхүл и-мэйлээр мэдэгдэнэ.

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

27. Хэрэглэх хууль

27.1. Хэрэглэгчээс гарсан гомдол, маргаантай асуудлыг энэхүү Үйлчилгээний нөхцөл болон Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

28. Шүүхийн харьяалал

- 28.1. Талуудын хооронд үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 28.2. Хэрэв Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

БУСАД

29. Үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 29.1. Энэхүү Үйлчилгээний нөхцөлийн заалтууд нь өөрчлөгдөх боломжтой. Хэрэв Үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт орон шинэчлэгдвэл Banana аппликейшн, Аппликейшн, эсхүл <https://bananamall.mn/> веб хуудсаар дамжуулан тухай бүрт нь мэдээлэл явуулж танилцуулна.
- 29.2. Хэрэглэгчийн захиалга баталгаажуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Үйлчилгээний нөхцөл нь Захиалга хүлээж авах хүртэлх хугацаанд өөрчлөгдсөн тохиолдолд Захиалга баталгаажуулах үеийн Үйлчилгээний нөхцөлийг дагаж мөрдөнө.

30. Банана онлайн дэлгүүрийн патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг

- 30.1. Банана онлайн дэлгүүрийн патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг нь ДМ-ийн өмч бөгөөд Банана онлайн дэлгүүрийн лого, нэр бусад загварыг хуулах, дуурайх зэргийг хатуу хориглоно.

31. Бараа бүтээгдэхүүний хямдрал, урамшуулал, хөнгөлөлт

- 31.1. ДМ нь Банана онлайн дэлгүүрийг өөрчлөх, сайжруулах, хөгжүүлэх болон бусад шаардлагаар Банана онлайн дэлгүүр зарлагдсан бараа бүтээгдэхүүний хямдрал, урамшуулал, хөнгөлөлтийг хэзээ түдгэлзүүлэх, өөрчлөх эсвэл дуусгах эсэхийг шийдэх эрхтэй байна.

--ooOoo--